



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

**“БҮС НУТГИЙН АВТО ЗАМ ХӨГЖҮҮЛЭХ, ЗАСВАР АРЧЛАЛТЫН ТӨСӨЛ”-ИЙН
УЛААНБААТАР-ДАРХАН ЧИГЛЭЛИЙН 204.11 КМ АВТО ЗАМЫН ӨРГӨТГӨЛ,
ШИНЭЧЛЭЛТИЙН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

ЗАХИАЛАГЧ:



Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам

САНХҮҮЖҮҮЛЭГЧ:



Монгол Улсын Сангийн яам Азийн хөгжлийн банк

ЗӨВЛӨХ:



БНЭУ-ын “Интерконтинентал Консалтантс энд Технократс” Компани болон Монгол Улсын “Ай Си Ти Сайн Консалтинг компани”

ГҮЙЦЭТГЭГЧ:



Багц-1: “Хэйлонжиан жиньи рөүд энд бридж” компани

Багц-3: Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг (групп)

Багц-5: Чайна Жео-Инженеринг Корпораци

НЭГ. ТӨСЛИЙН ЗАМЫН ТУХАЙ

Монгол Улс Азийн авто замын сүлжээнд 4 чиглэлээр хамрагддаг. Эдгээрийн нэг болох АН-3 чиглэлийн авто замд Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн 1026.6 км авто зам хамрагддаг. Монгол Улс, ОХУ болон БНХАУ-ын Засгийн газар хооронд байгуулсан 3 талт “Эдийн засгийн коридор” байгуулах хөтөлбөрийн хүрээнд Азийн авто замын сүлжээний АН-3 буюу Улаан Үд-Хиагт-Алтанбулаг-Дархан-Улаанбаатар-Сайншанд-Замын-Үүд-Эрээн-Бээжин-Тяньжин чиглэлийн авто замыг дамжин өнгөрөх тээвэрлэлтэд идэвхтэй ашиглах зорилтыг тавьсан.

Тус чиглэлийн авто замын Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын хэсэг нь сүлжээн дэх хамгийн их хөдөлгөөний эрчим бүхий хэсэг бөгөөд Монгол Улсын аж үйлдвэрийн томоохон төв, газар тариалан, мал аж ахуй, эдийн засгийн гол бүс нутгийг дайран өнгөрдөг.

Улаанбаатар - Дархан чиглэлийн авто замын эхний хэсэг болох Төв аймгийн Жаргалант сумын салаа зам хүртэлх 108 км авто замыг 1943 онд, 108-176 км-ийн хооронд 1972 онд, 176-204 км хоорондох хэсгийг 1974 онд барьж нийт замыг газар дээр нь холих аргаар хөнгөвчилсөн хатуу хучилттай болгосон байна. 1996-2000 онд Азийн хөгжлийн банк /АХБ/-ны “Авто замыг хөгжүүлэх” төслийн хүрээнд хэсэгчилсэн байдлаар их засвар, шинэчлэлт хийгдсэн. Мөн Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилт болон улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014-2015 онд тус чиглэлийн авто замд хэсэгчилсэн байдлаар нийт 25.4 км-т ээлжит засварын ажил хийгдсэн.




Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замаар нэвтрэн өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хоногийн дундаж эрчим **5802** тээврийн хэрэгсэл, оргил ачааллын үе буюу баяр наадмын өдрүүдэд хоногт дунджаар **12389** тээврийн хэрэгсэл зорчдог. Өсөн нэмэгдэж буй хөдөлгөөний эрчим болон замын ашиглалтын байдлаас шалтгаалж хөдөлгөөний нэвтрүүлэх чадвар маш муудсан. Нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахын тулд тус замыг 4 эгнээтэй болгон өргөтгөх зайлшгүй шаардлага гарсан.

Улаанбаатар-Дархан чиглэлийн авто зам нь огцом эргэлт, тойруу, өгсүүр, уруу болон үзэгдэх орчин хангалтгүй хэсгүүд ихтэй бөгөөд осол аваар ихээр гардаг 9 хар цэг бүртгэгдсэн байдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 284 дүгээр тогтоолоор Азийн авто замын сүлжээний АН-3 чиглэлийн авто замын хэсэг болох Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замыг 4 эгнээ бүхий хатуу хучилттай авто зам болгон өргөтгөн, шинэчлэх шийдвэр гаргасан.

Засгийн газрын шийдвэрийг ашиглагдаж байгаа 2 эгнээ авто замыг Азийн хөгжлийн банкны “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн хүрээнд өргөтгөн шинэчлэж, Европын сэргээн босголт, хөрөнгө оруулалтын банкны хөрөнгө оруулалтаар шинээр нэмж 2 эгнээ авто зам барихаар төлөвлөсөн.



ХОЁР: АХБ-ны МОН-3679/3786 зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”-ийн Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил

Төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг Монгол Улсын Засгийн газар болон АХБ хооронд 2018 оны 07 сарын 23-нд байгуулсан МОН-3679, 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан МОН-3786 зээлийн гэрээний хүрээнд шийдвэрлсэн.

- Төслийн замын нийт урт-204.11км
- Нийт төсөвт өртөг. USD 62,878,928.03
- Төсөл хэрэгжүүлэх хугацаа: 365 хоног.


Барилгын ажлын тоо хэмжээ

Улаанбаатар - Дархан чиглэлийн 204,11 км авто замын шинэчлэлтийн барилгын ажлыг нийт 5 багц болгон хуваан шинэчилж өргөтгөхөөр ажиллаж байна.

Төслийн хүрээнд нийт дөрвөлжин хоолой 103 ширхэг, дугуй хоолой 155 ширхэг, 8 гүүр, уулзвар, гарц авто зогсоолууд баригдана. НИЙТ 204.11 КМ ЗАМД ХИЙГДЭХ АЖИЛ

Авто замын нийт урт	204.11 км
Ухмал	1,473,642 м ³
Дүүргэлт	2,186,637 м ³
Суурийн доод үе хийх	806,833 м ³
Цементээр бэхжүүлсэн хөрсөөр суурь хийх	406,441 м ³
Цементээр бэхжүүлсэн буталсан чулуугаар суурь хийх	387,992 м ³
Асфальтобетон хучилт байгуулах	93,046 м ³
Хөвөө байгуулах	190,693 м ³
Гүүр 8 байршилд /нийт/	233.2 у/м
Бусад ус зайлуулах байгууламж -дөрвөлжин хоолой 103 байршилд, дугуй хоолой 155 байршилд	Нийт-258 байршилд

Төслийн зам барилгын ажлыг дараах 5 багц хэсгээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.



I багц: Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар модот давааны ар хүртэлх 37.26 км авто зам

II багц: Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто зам

III багц: Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто зам

IV багц: Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.08 км авто зам

V багц: Цайдамын хөндийгөөс Дарханы тойрог уулзвар хүртэлх 30.53 км авто зам

Зам барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөх, зам барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг АХБ-ны “Худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу олон улсын өрсөлдөөнт тендерээр зохион байгуулж дараах зөвлөх, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.

Зөвлөх компани: БНЭУ-ын “Интерконтинентал Консалтантс энд Технократс” Компани болон Монгол Улсын “Ай Си Ти Сайн Консалтинг компани”

Гүйцэтгэгч:

I багц: “Хэйлонжиан Жиньей Рөүд энд Бридж” компани

II багц: “Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг” (групп)

III багц: “Гуйжоу Хайвэй Инженеринг Групп”

IV багц: “Чайна Стэйт Шинжиан Констракшн Инженеринг” (групп)

V багц: “Чайна Жео-Инженеринг Корпораци”

Зам барилгын ажлын гэрээг 2020 оны 06 дугаар сарын 12-14-нд хийсэн. Багц тус бүрийн зам барилгын ажлыг 2019 оны 06 дугаар сарын 21-нд эхлүүлсэн. Гэрээгээр ажлыг 365 хоногийн хугацаанд гүйцэтгэж 2020 оны 06 дугаар сарын 21-нд дуусахаар төлөвлөсөн боловч КОВИД-19 цар тахал зам барилгын ажлын хэрэгжилтэд нөлөөлж байгаа нөхцөл байдалд үндэслэн АХБ-аас зам барилгын ажлын гэрээг 2020 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаагаас сунгах зөвшөөрөл олгогдож 3 багц хэсгийн гэрээг тус хугацаагаар сунгасан.

2019 онд хийж гүйцэтгэсэн ажил

2019 онд нийт ажлын 70 орчим хувийг гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч 24.86%-ийн ажлыг хийж гүйцэтгэсэн ба Багц 1-45.52%; Багц 2-9.49%; Багц 3-3.27%; Багц 4-5.3%; Багц 5-24.60%-ийн ажлыг тус тус гүйцэтгэсэн.

Зам барилгын ажлын график, төлөвлөгөөний хоцрогдолд дараах нөхцөл байдал нөлөөлсөн. Үүнд:

- Цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал (*нийт барилгын ажлын хугацаанд 28 хоног үргэлжилсэн бороотой байсан*);
- зарим гүйцэтгэгч байгууллагын ажлын удирдлага, зохион байгуулалт, менежментийн хангалтгүй байдал (*Багц 2 болон Багц 4 хэсгийн ажил дөнгөж 9, 5 хувьтай*);
- Нүүлгэн шилжүүлэлтэд ихээхэн хугацаа зарцуулагдсан (*зарим гүйцэтгэгч байгууллагуудын машин, техник, тоног төхөөрөмж 9 сард ажлын талбайд ирсэн*);
- Карьерын зөвшөөрөл хугацаа алдаж гарсан (*зарим карьерын байршил нь усны урсац бүрэлдэх эх хилийн заагтай давхцалтай шалтгаанаар зөвшөөрөл олгогдоогүй*);
- Багц 2 болон Багц 4 хэсгийн барилгын ажлын гэрээний өртөг хэт бага тул дотоодын компаниуд туслан гүйцэтгэгчээр орж ажиллах боломжгүй байсан.

Өвлийн улиралд түр замаар хөдөлгөөн нэвтрүүлэх боломжгүй /даваа, гүвээтэй хэсэгт халтиргаа, гулгаа үүсэх тул/ тул хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс төслийн үндсэн авто замын трассаар хөдөлгөөн нээх зайлшгүй шаардлагад нийцүүлэн 2019 оны 11 дүгээр сарын 01-нд авто замын үндсэн трассаар хөдөлгөөн нээсэн.

2020 оны ажлын хэрэгжилт

2020 оны зам барилгын бэлтгэл ажлыг 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлүүлж, үндсэн ажлыг 03 дугаар сарын 20-ны өдөр эхлүүлэхээр төлөвлөсөн боловч КОВИД -19 цар тахлын улмаас гадаад ажиллах хүч Монгол Улсад орж ирж чадаагүйгээс барилгын ажил төлөвлөсөн хугацаандаа эхэлж чадаагүй.

КОВИД-19 цар тахал зам барилгын ажлын хэрэгжилтэд нөлөөлж байгаа нөхцөл байдалд үндэслэн АХБ-аас зам барилгын ажлын гэрээг 2020 оны 12 сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаагаас сунгах зөвшөөрөл олгогдож 3 багц хэсгийн гэрээг тус хугацаагаар сунгасан.

Зам барилгын ажлын хэрэгжилтийн багц тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

БАГЦ 1 ХЭСЭГ:

**БАРУУН АЙМАГ САЛАХ ТОЙРОГ УУЛЗВАРААС ХАР МОТОД ДАВААНЫ АР ХҮРТЭЛХ
37.26 КМ АВТО ЗАМ**

Гүйцэтгэгч компани нь дотоодын туслан гүйцэтгэгчээр түр замын засварын ажлыг 2020 оны 03 сарын 22-ны өдөр эхэлсэн ба 04 сарын 25-ны өдрөөс үндсэн зам барилгын ажлыг эхлүүлсэн.

Тусган гүйцэтгэгчээр “Эсто” ХХК, “Болорболд зам” ХХК, “Дойч роуд” ХХК, “Нарны үүсгэл” ХХК тус тус ажиллаж байна.

2020 оны 10 сарын 25-ны өдрийн байдлаар ажлын талбайд нийт 244 ажиллах хүч /үүнээс гадаадын 7, дотоодын 237 хүн/, 108 машин механизм ажиллаж байна.

Ажлын гүйцэтгэл 83.15 хувьтай. Зам барилгын хучилтын ажлыг 10 дугаар сард багтааж дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

БАГЦ 3 ХЭСЭГ:

УРЬХАНААС СҮМБЭРИЙН УУЛЗВАР ХҮРТЭЛХ 45.74 КМ АВТО ЗАМ

Гүйцэтгэгч компани нь түр замын засварын ажлыг 2020 оны 04 сарын 17-ны өдөр эхэлсэн ба 05 сарын 23-ны өдрөөс үндсэн зам барилгын ажлыг эхлүүлсэн.

2020 оны 10 сарын 25-ны өдрийн байдлаар ажлын талбайд нийт 133 ажиллах хүч /үүнээс гадаадын 27, дотоодын 106 хүн/, 86 машин механизм ажиллаж байна.

Ажлын гүйцэтгэл 68.54 хувьтай байна.

БАГЦ 5 ХЭСЭГ:

**БУЮУ ЦАЙДАМЫН ХӨНДИЙГӨӨС ДАРХАНЫ ТОЙРОГ УУЛЗВАР ХҮРТЭЛХ 30.53 КМ
АВТО ЗАМ**

Гүйцэтгэгч компани нь түр замын засварын ажлыг 2020 оны 03 сарын 10-ны өдөр эхэлсэн ба 04 сарын 02-ны өдрөөс үндсэн зам барилгын ажлыг эхлүүлсэн.

2020 оны 09 сарын 10-ны өдрийн байдлаар ажлын талбайд нийт 144 ажиллах хүч /үүнээс гадаадын 17, дотоодын 127 хүн/, 93 машин механизм ажиллаж байна.

Ажлын гүйцэтгэл 69.31 хувьтай байна.

БАГЦ 2 ХЭСЭГ:

ХАР МОДОТ ДАВААНЫ АРААС УРЬХАН ХҮРТЭЛХ 45.5 КМ АВТО ЗАМ

БАГЦ 4 ХЭСЭГ:

СҮМБЭРИЙН УУЛЗВАРААС ЦАЙДАМЫН ХӨНДИЙ ХҮРТЭЛХ 45.08 КМ АВТО ЗАМ

Гүйцэтгэгч байгууллага дээрх 2 багц хэсгийн 2020 оны зам барилгын ажлыг дотоодын туслан гүйцэтгэгчээр эхлүүлэх арга хэмжээ авсан боловч үр дүн гараагүй. Гүйцэтгэгч компанийн байрладаг БНХАУ-ын Шинжиан мужид КОВИД-19 цар тахлын улмаас тогтоосон хорио цээрийн улмаас гадаад ажиллах хүч Монгол Улсад орж ирж чадахгүй болсонтой холбогдуулан гүйцэтгэгч байгууллагаас 2020 оны 08 сарын 16-ны өдөр гэрээ цуцлах хүсэлтээ ирүүлсэн. Гэрээ цуцлах үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Ийнхүү 2 багц хэсгийн гүйцэтгэгчийн дахин сонгон шалгаруулах шаардлага гарсан. Гүйцэтгэгчийг АХБ-ны Худалдан авах ажиллагааны журмын дагуу сонгон шалгаруулна. Дараагийн гүйцэтгэгч байгууллагын сонгон шалгарах хүртэлх хугацаанд тус багц хэсгүүдэд хамаарах авто замд хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хүрээнд зарим засварын ажлыг хийж гүйцэтгэж байна.

Энэ хоёр хэсэгт Захиалагчийн зүгээс дараагийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах үйл ажиллагааг өвлийн уриралд зохион байгуулж, зам барилгын ажлыг 2021 оны 3 дугаар сард багтаан эхлүүлж, 2021 оны 11 сард дуусгахаар төлөвлөж байгаа болно.